



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,
Утас: 51-263051, Факс: (976) 7004-3479
E-mail: info@energy.gov.mn

2021. 10. 13 № А/3647
танай 2021. 10. 04 -ны № 38 -т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Эрхэм Улсын Их Хурлын гишүүн танд энэ өдрийн мэнд хүргэе.

Танаас ирүүлсэн асуултад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. "Таван толгой түлш" ХХК нь 2020-2021 оны өвлийн оргил ачааллын үед хоногт 3,500-4,300 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэн хэрэглэгчдэд нийлүүлж ажилласан бөгөөд 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд үйлдвэрийн их засварын ажлыг гүйцэтгэн 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс шугамуудыг үе шаттайгаар ажиллагаанд оруулж сайжруулсан шахмал түлш нөөцлөх ажлыг эхлүүлсэн.

Сайжруулсан шахмал түлшний борлуулалт эхэлсэн өдөр буюу 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлш 69,851 тонн буюу 29 хоногийн (өвлийн оргил ачааллын 19 хоног) нөөц, барьцалдуулагч 682 тонн буюу 10 хоногийн нөөц бүрдүүлсэн.

2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлшний нөөц 64,273 тонн, барьцалдуулагчийн нөөц 2,071 тонн байна.

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, нөөц бүрдүүлэх ажилд доголдол үүсээгүй бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр борлуулалтын 40 цэг, 10 дугаар сарын 3-ны өдөр 128 цэг ажиллаж байсан нь иргэдийг сайжруулсан шахмал түлш худалдан авахад очер, дараалал ихэссэн шалтгаан болсон байна.

"Таван толгой түлш" ХХК-иас асуудлыг шийдвэрлэхээр борлуулалтын цэгийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлэн 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 500 цэгээр иргэдэд сайжруулсан шахмал түлш борлуулж байна.

2. 2020-2021 оны халаалтын улиралд гэр хорооллын 171,482 айл өрхөд нийт 572,175 тонн сайжруулсан шахмал түлш борлуулсан нь нэг өрх дунджаар 3.3 тонн түлш хэрэглэсэн тооцоо гарч байна.

"Таван толгой түлш" ХХК нь 2021-2022 оны халаалтын улиралд 582,900 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэн нийслэлийн түүхий нүүрс хориглосон бүсийн 171,482 өрхөд нийлүүлэхээр төлөвлөсөн нь нэг өрхөд дунджаар 3.4 тонн түлш ноогдох бөгөөд энэ хугацаанд 300 орчим өрхийн дунд 1 борлуулалтын цэг буюу нийт 600 цэг ажиллуулахаар төлөвлөсөн.

Цаашид нөөцийг тогтмол хэмжээнд барих, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор баруун бүсийн үйлдвэрт бутлуурын байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, зүүн бүсийн үйлдвэрт хатаах байгууламж, 25 кг-ын шуудайнд савлах тоног төхөөрөмж угсарч ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

170602266

3.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын Эрчим хүчний сайдын 2021 оны төсвийн багцад Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах /Ховд/ төсөл, арга хэмжээг 2021-2023 онд санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Энэхүү төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ-аас Хөшөөтийн уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийг боловсруулах ажлыг гүйцэтгэн, Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, хурлаар тус ТЭЗҮ-ийг дэмжих шийдвэр гарсан.

Дээрх ТЭЗҮ-ийг үндэслэн Эрчим хүчний яамнаас “Хөшөөтийн уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах /Ховд/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийн хугацаанд нээлттэй тендер зарласан бөгөөд тендерт оролцогчдоос нэг ч тендерт ирүүлээгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулан 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 08 дугаар сарын 22-ны өдрийн хооронд дахин нээлттэй тендер зарласан бөгөөд “Смарт энтерпрайз” ХХК болон “Ховдын өргөө” ХХК-иас тендерийн материал ирүүлсэн.

Үнэлгээний хороо ирүүлсэн тендерт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан бөгөөд дээрх 2 компаниас ирүүлсэн материал тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй тул буцаахаар шийдвэрлэж захиалагчид танилцуулан, 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр тус хоёр компанид буцаах мэдэгдлийг хүргүүлсэн.

“Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах” төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер 2 удаа амжилтгүй болсон тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн.

Үүнтэй холбогдуулан төр болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж, өрсөлдөөнийг бий болгох зорилгоор “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний баруун болон зүүн үйлдвэрийн барилга, түлшний үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжийн угсралтыг хийж гүйцэтгэсэн гүйцэтгэгчийн судалгааг “Тавантолгой түлш” ХХК-иас гаргуулан авч, үнэлгээний хорооны хурлаар хэлэлцүүлэн өмнө тендерт оролцсон оролцогч компаниуд болон нийт 10 компанид тендерийн урилгыг хүргүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн в/3382 тоот албан бичгээр компаниудад урилгыг хүргүүлсэн бөгөөд 2021 оны 10 дугаар сарын 8-ны өдөр тендерийг нээн, үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж байна.

САЙД



Н.ТАВИНБЭХ